

Сурагчийн зөвшөөрлийн маягт

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа,

Миний бие энэ хичээлийн жилд багш нарыг боловсролын салбарт чадварлаг мэргэжилтэн болгоход чиглэсэн үнэлгээний хөтөлбөрт оролцож байгаа юм. Багшийн мэргэжлийн стандартын үндэсний зөвлөлөөс (**Үндэсний зөвлөл**) зохион байгуулж буй энэхүү үнэлгээний хөтөлбөрт би сайн дурын үндсэн дээр оролцож байна. Энэхүү үнэлгээний гол зорилго нь чадварлаг багшийн эзэмшвэл зохих мэдлэг, практик ур чадваруудыг багш хүн харуулж чадаж байгаа эсэхийг шалгаж, шийдвэр гаргах, мөн сурагчдын сурлагын үр дүнг сайжруулах, сурган хүмүүжүүлэх шилдэг арга барилыг сурталчлан урам зориг өгөх явдал юм.

Энэхүү үнэлгээнд хамрагдахын тулд би таны хүүхдийн ангид орж буй хичээлийн үеэр авсан дүрс бичлэг болон/эсвэл гэрэл зургийг хавсаргах шаардлагатай юм. Хэдийгээр бичлэг/гэрэл зураг нь сурагчдыг харуулж, хамруулах боловч гол зорилго нь миний заах арга барилыг харуулах явдал юм. Үнэлгээний явцад таны хүүхдийн дүр төрх, дуу хоолойг видео бичлэгт буулгаж, зургийг нь авч болох бөгөөд дараа нь эдгээр бичлэг, гэрэл зургийг Үндэсний зөвлөлд хүргүүлнэ. Үндэсний зөвлөлд миний өөрийн бичсэн тайлбарын хуудас, хичээлийн материал, эсээ, анги танхимын төлөвлөгөө, даалгавар болон тайлбар зэрэг материалуудыг (**илгээх материал**) илгээх болно.

Нэмж дурдахад, үнэлгээний нэг хэсэг болгон багшийн заах арга барилыг харуулах зорилгоор сурагчдын хийсэн даалгавар, бие даалт зэргийг (**Сурагчийн бүтээл**) илгээх шаардлага гарч болзошгүй бөгөөд үүнд таны хүүхдийн зарим бүтээлийг багтааж болно. Үнэлгээний нэг хэсэг болгон илгээх ямарваа материал, бичлэг дээр сурагчийн овог харагдахгүй болно.

Үндэсний зөвлөл миний илгээсэн материалыг ашиглах бүрэн эрхтэй бөгөөд би эдгээр материалтай холбоотой бүх өмч, эрхээ Үндэсний зөвлөлд шилжүүлж байна. Мөн Үндэсний зөвлөл миний илгээж буй сурагчийн бүтээлтэй холбоотой тодорхой эрхийг олж авах юм. Үндэсний зөвлөл нь боловсрол, сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор миний хүргүүлсэн материал, сурагчийн бүтээлийг өөрийн эрх мэдлийн хүрээнд ашиглах эрхтэй. Үндэсний зөвлөл нь ямар ч нөхцөлд нууцлалын бодлогоо баримталдаг бөгөөд үүнийг Үндэсний зөвлөлийн гэрчилгээний удирдамжаас харж болно.: http://www.nbpts.org/wp-content/uploads/Guide_to_NB_Certification.pdf. Тухайлбал, Үндэсний зөвлөл болон үнэлгээний үйл явцад оролцож буй аливаа гуравдагч этгээд миний үнэлгээтэй холбоотойгоор илгээсэн материалуудыг ашиглаж болох ба Үндэсний зөвлөл нь өөрийн хэвлэл, нийтлэлд сурагчийн бүтээлийг мөн ашиглаж болох юм. Мөн Үндэсний зөвлөл нь миний илгээж буй материал болон сурагчийн бүтээлийг ATLAS хэмээх нууц үгээр хамгаалагдсан онлайн мэдээллийн санд байршуулахад надаас тусгай зөвшөөрөл авч болох бөгөөд үүнд боловсрол, судалгаа шинжилгээ, мэргэжил дээшлүүлэх зорилгоор бусад хүмүүс хандах боломжтой. Материалуудыг зөвхөн надаас тусдаа ATLAS-ын зөвшөөрлийн бичиг, маягтыг авсны дараа ATLAS-д байршуулах болно. Та ATLAS онлайн мэдээллийн санд хамаарах ерөнхий нөхцөлтэй энд дарж танилцана уу: <https://atlas.nbpts.org/terms>. Үндэсний зөвлөл нь материалууд болон сурагчийн бүтээлд хандах эрх олгосон хүмүүсээс төлбөр авч болно. Ингэснээр хувь хүмүүс, сурган хүмүүжүүлэгчид, сурагчид зэрэг хүмүүс миний илгээсэн материал болон сурагчийн бүтээлийг үзэх боломжтой болно. Гэсэн хэдий ч таны хүүхдийн овог нэрийг материалууд болон сурагчийн бүтээлд оруулахгүй.

Би Үндэсний зөвлөлд бичлэг, гэрэл зураг өгөх талаар танаас зөвшөөрөл хүсэхээр энэхүү захидлыг бичиж байна. Эдгээр материал нь таны хүүхдийн дуу хоолой, дүр төрхийг агуулсан байж болох бөгөөд зөвхөн энэ захидал болон хавсаргасан Сурагчийн зөвшөөрлийн маягтад дурдсанчлан Үндэсний Зөвлөл ашиглаж, хуваалцах болно. Зөвшөөрлөө өгснөөр та миний үнэлгээнд оруулж буй хүүхдийнхээ аливаа бүтээлийг хязгааргүй, эргэлт буцалтгүй, үнэ төлбөргүйгээр ашиглах эрхийг Үндэсний зөвлөлд олгож байгаа хэрэг юм. Үүнд аливаа сурагчийн бүтээлтэй холбоотой зохиогчийн эрх, олон нийтэд нийтлэх болон бусад холбогдох эрхүүдийг хэрэгжүүлэх орно. Цаашлаад, та илгээсэн материалууд эсвэл сурагчийн бүтээлийг ашиглахтай холбоотой (хувийн нууцад халдах гэх мэт) аливаа асуудлаар Үндэсний зөвлөлийг шүүхэд өгөхгүй байхыг зөвшөөрч байгаа болно.

Хэрэв та хүүхдээ дээр дурдсан үйл ажиллагаанд оролцохыг мөн энэхүү захидалд дурдсанчлан Үндэсний зөвлөлд илгээсэн материал болон сурагчийн бүтээлийг ашиглахыг зөвшөөрч байгаа бол хавсаргасан сурагчийн зөвшөөрлийн маягтад гарын үсэг зурна уу (Хэрэв таны хүүхэд 18 ба түүнээс дээш настай бол хүүхдээрээ уг маягтад гарын үсэг зуруулна уу). Би энэ маягтыг таны зөвшөөрлийн нотлох баримт болгон хадгалах бөгөөд хэрэв хүсвэл Үндэсний зөвлөлд өгч болно. Хэрэв та хүүхдээ оролцуулахыг зөвшөөхгүй байгаа бол би таны хүүхдийг ямар нэгэн бичлэг, гэрэл зурагт оруулахгүй ба сурагчдын бүтээлээс таны хүүхдийн бүтээлийг хасах болно.

Танд баярлалаа.

Хүндэтгэсэн,

(Оролцогчийн гарын үсэг)

Сурагчийн царай төрх, дуу хоолойг ил тод гаргах тухай зөвшөөрлийн маягт

(насанд хүрээгүй сурагчийн эцэг эх/хууль ёсны төлөөлөгч **мөн** энэ үнэлгээнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны бүх сурагч бөглөнө)

Сурагчийн нэр: _____

Сургуулийн нэр болон багшийн нэр: _____

Таны хаяг: _____

Эцэг эх / хууль ёсны асран хамгаалагч

Би дээр дурдсан хүүхдийн эцэг эх/хууль ёсны асран хамгаалагч мөн болно. Би энэхүү маягт (Захидал)-ын хавсаргасан Багшийн мэргэжлийн стандартын үндэсний зөвлөлөөс (Үндэсний зөвлөл) багш нарын үнэлгээ хийж байгаа талаарх захидлыг хүлээн авч уншиж танилцсан бөгөөд дараах зүйлсийг зөвшөөрч байна.

Би багш (Та) болон дээр дурдсан сургуульд _____ (Сургуулийн нэр), болон _____ (Багшийн нэр) миний хүүхдийг хичээлд оролцож байх үед хүүхдийнхээ нүүр царай, дуу хоолойг видео бичлэгт буулгаж, гэрэл зураг авахыг ЗӨВШӨӨРЧ БАЙНА. Мөн эдгээр бичлэг, зургийн хуулбарыг Үндэсний зөвлөлд өгөх; Мөн миний хүүхдийн ангийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон хийж болох бүтээлийн хуулбарыг доор дурдсан нөхцөл, болзлын дагуу Үндэсний зөвлөлд өгөхийг би танд болон сургуульд **ЗӨВШӨӨРЧ БАЙНА**.

1. Үндэсний зөвлөлд илгээж буй бичлэг, зураг, сургуулийн бүтээл дээр миний хүүхдийн овог нэр гарахгүй.
2. Үндэсний зөвлөл нь таны Үндэсний зөвлөлд илгээсэн материалыг зөвхөн энд дурдсан зорилго, нөхцөлийн дагуу ашиглаж болно.
3. Үндэсний зөвлөл нь таны илгээсэн материалын хуулбарыг дараах байдлаар ил болгож болно. (а) ATLAS мэдээллийн сан гэгддэг боловсрол, судалгаа, мэргэжлийн хөгжлийн зорилгоор Үндэсний зөвлөлийн нууц үгээр хамгаалагдсан мэдээллийн санд ханддаг хүмүүст; мөн (б) Үндэсний зөвлөлийн ажил, энэ төрлийн материал агуулсан хэвлэлд.

Би танд болон сургуульд миний хүүхдийн зураг, дуу хоолойг бичих, ангийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон бэлтгэсэн бүтээлийг нь хуулбарлах, Үндэсний зөвлөлд дэлгэхийг **ЗӨВШӨӨРӨХГҮЙ БОЛНО**.

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг: _____ Огноо: _____

Насанд хүрсэн сурагч

Би дээр нэрлэгдсэн сурагч мөн бөгөөд 18-аас дээш настай болно. Би энэхүү маягт (Захидал)-ын хавсаргасан Багшийн мэргэжлийн стандартын үндэсний зөвлөлөөс (Үндэсний зөвлөл) багш нарын үнэлгээ хийж байгаа талаарх захидлыг хүлээн авч уншиж танилцсан бөгөөд дараах зүйлсийг зөвшөөрч байна.

Би багш (Та) болон дээр дурдсан сургуульд _____ (Сургуулийн нэр), болон _____ (Багшийн нэр) миний хичээлд оролцож байх үед миний нүүр царай, дуу хоолойг видео бичлэгт буулгаж, гэрэл зураг авахыг ЗӨВШӨӨРЧ БАЙНА. Мөн эдгээр бичлэг, зургийн хуулбарыг Үндэсний зөвлөлд өгөх; Мөн миний ангийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон хийж болох бүтээлийн хуулбарыг доор дурдсан нөхцөл, болзлын дагуу Үндэсний зөвлөлд өгөхийг би танд болон сургуульд **ЗӨВШӨӨРЧ БАЙНА**.

1. Үндэсний зөвлөлд илгээж буй бичлэг, зураг, сургуулийн бүтээл дээр миний овог нэр гарахгүй.
2. Үндэсний зөвлөл нь таны Үндэсний зөвлөлд илгээсэн материалыг зөвхөн энд дурдсан зорилго, нөхцөлийн дагуу ашиглаж болно.
3. Үндэсний зөвлөл нь таны илгээсэн материалын хуулбарыг дараах байдлаар ил болгож болно. (а) ATLAS мэдээллийн сан гэгддэг боловсрол, судалгаа, мэргэжлийн хөгжлийн зорилгоор Үндэсний зөвлөлийн нууц үгээр хамгаалагдсан мэдээллийн санд ханддаг хүмүүст; мөн (б) Үндэсний зөвлөлийн ажил, энэ төрлийн материал агуулсан хэвлэлд.

Би танд болон сургуульд миний нүүр царай, дуу хоолойг бичих, ангийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон миний бэлтгэсэн материалыг хуулбарлах, Үндэсний зөвлөлд дэлгэхийг **ЗӨВШӨӨРӨХГҮЙ БОЛНО**.

Сурагчийн гарын үсэг: _____ Огноо: _____

Төрсөн огноо: _____